

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

### Ангилалтын код 13.020

<b>Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага</b>	<b>MNS 5918 : 2008</b>
<b>Environment. Re-vegetation of destroyed land. General technical requirements</b>	<b>MNS 4918:2000 -ийн оронд MNS 4919:2000 -ийн оронд</b>

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2009 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

### 1 Зорилго

Энэ стандарт нь эвдэрсэн газрыг ургамалжуулахад тавих ерөнхий шаардлагыг тогтооно.

### 2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэв. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- MNS 5917:2008, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
- MNS 5915:2008, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
- MNS 5916:2008, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт

### 3 Техникийн шаардлага

**3.1** Эвдэрсэн газрыг ургамалжуулахад тарих ургамлын төрөл, зүйл, тарих арга ажиллагааг тухайн талбайн хөрсний бүтэц, механик бүрэлдэхүүн, газрын гадаргын налуу болон бусад нөхцөлийг харгалзан сонгох ба тухайн төсөлд хийсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчны төлөв байдлын үнэлгээг үндэслэнэ.

**3.2** Техникийн нөхөн сэргээлт хийсэний дараа шимт хөрсөөр хучилт хийгээгүй удсан талбайн өнгөн хэсгийг 18 см-ээс доошгүй гүн сийрүүлсний хийсний дараа үржил шимт хөрсөөр хучна.

**3.3** Хучилт хийх хөрсний механик бүтэц, үржил шим, уусмалын орчин нь холбогдох стандартын шаардлага хангахгүй тохиолдолд шим, эрдэс бордоогоор бордох, механик бүтцийг сайжруулах арга хэмжээ авна.

**3.4** Хоёроос нэг настай ургамлыг нөхөн сэргээлтэд хэрэглэхгүй.

**MNS 5918 : 2008**

**3.5** Тарих хугацааг сонгон авсан ургамлын төрөл зүйлийн онцлогт тохируулан, тариалах газар нутгийн бүс, цаг уурын нөхцөлтэй уялдуулан 1-р хүснэгт үзүүлсэний дагуу сонгоно.

1-р хүснэгт

№	Байгалийн бүс	Усалгаагүй нөхцөл	Усалгаатай нөхцөл
1	Уулархаг бүс	6-р сарын 3 дахь 10 хоногт	5-р сарын 3 дахь 10 хоногт
2	Ойт хээр, хээрийн бүс	6-р сарын 2 дахь 10 хоногт	5-р сарын 2 дахь 10 хоногт
3	Говь, цөлийн бүс	5-р сарын 3 дахь 10 хоногт	5-р сарын эхний 10 хоногт

**3.4** Эвдэрсэн газрыг ургамалжуулахад соёололт, цэвэршилтээр I, II ангид тэнцэх үр хэрэглэнэ. Үүнийг 2-р хүснэгтэд үзүүлэв.

2-р хүснэгт

№	Ургамал	Соёололт, %		Цэвэршилт, %	
		I анги	II анги	I анги	II анги
1	Царгас	70	60	90	80
2	Сибирийн өлөнгө	70	50	95	90
3	Дагуурын өлөнгө	60	40	90	80
4	Согоовор	75	65	95	90
5	Ерхөг	80	65	95	90

**3.5** Ургамалжуулах талбайн налуу 15<sup>0</sup>-аас их бол налуугийн хөндлөн, эсвэл тоонолжлон тарина.

**3.6** Ургамлын үрийг 3-р хүснэгтэд үзүүлсэн хэмжээгээр тариална.

3-р хүснэгт

№	Ургамлын нэр	Латин нэр	1 га-д /кг-аар/
1	Царгас	Medicago L	8-10
2	Хүцэнгэ	Onobrychis L	25-30
3	Хошоон	Melilotus Hill	15-20
4	Согоовор	Bromus L	18
5	Өлөнгө	Elymus L	15-20
6	Ерхөг	Gaertu	15-18

**3.7** Тарихын өмнө олон наст ургамлын 100 г үрийг 200 мл усанд 24 цагаас багагүй хугацаанд дэвтээж 6-8 цаг наранд байлган сэврээж, соёолох чадварыг нь нэмэгдүүлнэ.

**3.8** Үрийг 2,0 см –ээс 2,5 см гүнд суулгана.

**3.9** Нөхөн сэргээлтэд тухайн нутагт ургадаг мод, бут сөөг ургамлыг ашиглах чиглэлийг баримтална. Хангайн бүсэд хус, улиас, улиангар, шинэс, нарс, гацуур зэрэг модыг эгнээ хооронд 5 м, мод хооронд 4 м (1 га-д 500 ш), хайлаасыг эгнээ хооронд 4 м, мод хооронд 3 м (1 га-д 833 ш), тал хээр болон говийн бүсэнд улиас, улиангарыг эгнээ хооронд 4 м, мод хооронд 3 м, (1 га-д 833 ш), хайлаасыг эгнээ хооронд 3 м мод хооронд 3 м (1 га-д 1111 ш), бүх төрлийн бургас болон гүйлс, буйлс, долоогоно, өрөл зэрэг бут сөөгийг бүс харгалзахгүйгээр эгнээ хооронд 2 м, ургамал хооронд 1,5 м –ээс 2 м (1 га-д 3333 ш –ээс 2500 ш) зайтай суулгана.

**3.10** Үхрийн нүдийг эгнээ хооронд 3 м, ургамал хооронд 1 м (1 га-д 3333 ш), чацарганыг эгнээ хооронд 4 м, ургамал хооронд 1,5 м (1666 ш), интоор, бөөрөлзгөнө зэрэг жимсгэнийг үхэр нүдний адилаар (1 га-д 3333 ш) аль ч бүсэнд суулгана.

**3.11** Мод бут сөөгийг монгол орны нөхцөлд 04 дүгээр сарын 20-оос 05 дугаар сарын 15-ны дотор тарина. Говь цөлийн бүсэд энэ хугацааг 5 -аас 10 хоногоор эрт тарьж болно.

**3.12** Мод, бут, сөөгийг намар аль ч бүсэд газар хөлдөхөөс 20-оос доошгүй хоногийн өмнө буюу 10 дугаар сарын 05-аас 10-дугаар сарын 20-ны өдрийн хооронд нөхөн сэргээлтийн талбайд тарьж суулгана.

**3.13** Нөхөн сэргээлтэд тарих модны суулгацын өндөр 1,5 м-ээс доошгүй, 2-3 буюу түүнээс дээш салаа мөчиртэй, жимс, жимсгэнийн суулгац 50 см-ээс намгүй, 2-3 салаа мөчиртэй байна. Мод, бутны суулгацын үндэс гэмтээгүй хэвийн, сайн хөгжилтэй байна.

**3.14** Нөхөн сэргээлтэд тарих бүх төрлийн суулгац материал нь өвчин, хортонд нэрвэгдээгүй, хөлдөж гэмтээгүй эрүүл бөгөөд үндэс хэвийн хөгжилтэй байна.

**3.15** Тариалсны дараа олон наст ургамлын соёололт, бут, сөөг, суулгацын ургалтын байдлыг харгалзан нэмж тарих буюу шаардлагатай гэж үзвэл агротехникийн бусад арга хэмжээг явуулна.

## **ТӨГСӨВ.**